

“ДУНДМАНХАЙДАЙ АУДИТ” ХХК

“ЭРЧИМБАЯН ӨЛГИЙ” ХК

АУДИТЛАСАН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2023 оны 12 дугаар сарын 31-ний

өдрөөр дуусгавар болсон

<u>Агуулга</u>	<u>Хуудас</u>
КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛ	1
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТАЛААРХИ УДИРДЛАГЫН БАТЛАМЖ МЭДЭГДЭЛ	2
ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3-4
2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	
Аудитласан санхүүгийн байдлын тайлан	5
Аудитласан дэлгэрэнгүй орлогын тайлан	6
Аудитласан өмчийн өөрчлөлтийн тайлан	7
Аудитласан мөнгөн гүйлгээний тайлан	8
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	9-26

“ЭРЧИМБАЯН ӨЛГИЙ” ХК

КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛ

ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧИД:

Нийт 263 хувьцаа эзэмшигч

ХАРИЛЦАГЧ БАНК:

Хас Банк,
Хаан Банк,
Голомт Банк,
Төрийн Банк
Капитрон Банк

КОМПАНИЙН БАЙРШИЛ:

Монгол улс, Баян-Олгий аймаг, Олгий, 4-р
баг, Их булан

КОМПАНИЙН УДИРДЛАГА:

Захирал: М. Тилеуберди
Гар утас:

Ерөнхий нягтлан бодогч – К. Ерболат
Гар утас: 99421155

И-Мэйл: erchim_murat@yahoo.com

АУДИТЫН КОМПАНИЙН БАЙРШИЛ:

Нягтлан бодох бүртгэл хяналтын
итгэмжлэгдсэн байгууллага –
“ДУНДМАНХАЙДАЙ АУДИТ” ХХК

Чингэлтэй дүүрэг, 2-р хороо,
Төмөрчний гудамж, Их найман шарга,
10 давхар

Аудиторуудын утас: 99085151
91991462

И-Мэйл: byambaahunnu@yahoo.com

“ЭРЧИМБАЯН ӨЛГИЙ” ХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн тайлангийн талаархи удирдлагын батламж мэдэгдэл

Хараат бус аудиторуудын толилуулсан тайланд заасан аудиторуудын үүрэг хариуцлагатай хамтад нь авч үзэх доор дурьдсан батламж мэдэгдэлийг санхүүгийн тайланг бэлтгэхэд аудиторууд болон удирдлагын үүрэг хариуцлагыг зааглах зорилгоор гаргалаа.

Компанийн удирдлага нь тус компанийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх санхүүгийн байдал, мөн үеэр дуусгавар болсон жилийн үйл ажиллагааны үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон тодруулгаас бүрдэх санхүүгийн тайланг бүх материаллаг үзүүлэлтүүдээр СТОУС-ын дагуу үнэн зөв бэлтгэх, толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайлан бэлтгэхэд удирдлага дараах хариуцлагыг хүлээнэ:

- Нягтлан бодох бүртгэлийн зохих зарчмуудыг сонгож, тууштай мөрдөх,
- Үндэслэл бүхий үнэлгээ тооцоолол хэрэглэх,
- СТОУС-ын шаардлагыг мөрдөх,
- Санхүүгийн тайланг бэлтгэхдээ компани нь ирээдүйд үйл ажиллагаагаа тасралтгүй үргэлжлүүлнэ гэсэн төсөөллийг баримтлах,

Мөн удирдлага нь санхүүгийн тайлантай холбоотой дараах үүргийг хүлээнэ.

- Үр өгөөжтэй, найдвартай дотоод хяналтын системийг боловсруулж, нэвтрүүлж, үйл ажиллагааг нь хангах,
- Компанийн санхүүгийн байдлын тухай үнэн зөв илэрхийлэх мэдээллийг ямар ч үед илэрхийлэх нягтлан бодох бүртгэлийн системийг ажиллуулж, санхүүгийн тайлангаа СТОУС-ын шаардлагад нийцүүлэх,
- Нягтлан бодох бүртгэлийг Монгол улсын зохих хууль тогтоомжийн дагуу хөтлөх,
- Өөрийн эрх үүргийн хүрээнд компанийн хөрөнгийг бүрэн бүтэн байлгах арга хэмжээг авах,
- Алдаа, зальт ажиллагаа болон бусад хууль бус ажиллагааг илрүүлж, урьдчилан сэргийлэх,

Захирал

Нягтлан бодогч

.....
М. Тилеуберди

.....
К. Ерболат



**ДУНДМАНХАЙДАЙ
АУДИТ ХХК**

15170 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Төмөрний гудамж, Их найман шарга 10 даяар,
Утас: 9906-5151, 9199-1482 Факс: (975-11) 32-52-62
E-mail: byambaa@hullu@yahoo.com, http://www.dumaudit.mn

2024.03.29 № 56
танай _____-ны № _____-г

**“ЭРЧИМБАЯН ӨЛГИЙ” ХК-ийн
Хувьцаа эзэмшигчдэд**

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Санхүүгийн Тайлангийн Аудитын Талаарх Тайлан

Дүгнэлт

Бид “Эрчимбаян Өлгий” ХК-ийн 2023 оны 12 сарын 31-ээрх өдрөөр дуусгавар болсон санхүүгийн байдлын тайлан, жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний үзэж байгаагаар эдгээр санхүүгийн тайлангууд нь бүхий л материаллаг асуудлаар “Эрчимбаян Өлгий” ХК-ийн 2023 оны 12 сарын 31-ээрх санхүүгийн байдал, тухайн жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартуудын дагуу үнэн зөв толидуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-уудын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа энэ тайлангийнхаа Санхүүгийн Тайлангийн Аудитад хүлээх Аудиторын Үүрэг Хариуцлага гэсэн хэсэгт харуулав. Бид санхүүгийн тайлангийн энэхүү аудитын ажилд хамаарах ёс зүйн шаардлагуудын дагуу Компаниас хараат бус ба эдгээр шалгууруудын дагуух ёс зүйн бусад үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Олж авсан аудитын баримт нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай, тохиромжтой гэж итгэж байна.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлээр аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлууд юм. Санхүүгийн

тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн тусдаа дүгнэлт гаргаагүй болно.

Бусад мэдээлэл

Бид аудитын явцад компанийн жилийн санхүүгийн тайлан, гүйцэтгэх удирдлагын ажлын тайлан, хувьцаа эзэмшигчдийн хурлын протокол, шийдвэртэй танилцахад аудитын тайланд нөлөөлөхүйц материаллаг зөрчил илрээгүй болно.

Удирдлага болон Засаглах Эрх Мэдэл Бүхий Эгтгээдүүдийн Санхүүгийн Тайланд хүлээх Үүрэг Хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайлагналын олон улсын стандартуудын дагуу эдгээр санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах хариуцлага хүлээх бөгөөд мөн залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжтой болгоход зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

Санхүүгийн Тайлангийн Аудитад хүлээх Аудиторын Үүрэг Хариуцлага

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ анги эсэх талаар ул үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлдэг гэсэн нотолгоо болохгүй. Буруу илэрхийлэх явдал нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв тэр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог.



Ж.БЯМБАЖАВ
“Дундманхайдай Аудит” ХХК
Монгол Улс, Улаанбаатар хот
2024 он 03 сар 29 өдөр

"ЭРЧИМБАЯН ӨЛГИЙ" ХК
АУДИТЛАСАН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН
 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил

(Төгрөгөөр)

ХӨРӨНГӨ	<i>Лай</i>	2023 он	2022 он
Эргэлтийн хөрөнгө:			
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	4	77,952,137.51	61,439,573.74
Дансны авлага	5	2,412,455,522.91	1,892,065,946.07
Татвар, НДШ-ийн авлага		30,678.24	
Бусад авлага	6	732,151,775.12	326,844,342.96
Бусад санхүүгийн хөрөнгө			
Бараа материал	7	625,678,920.67	672,964,609.37
Урьдчилж төлсөн зардал	8	73,162,620.00	13,696,340.00
Бусад эргэлтийн хөрөнгө			
Борлуулал зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө			
Эргэлтийн хөрөнгийн дүн		3,921,431,654.45	2,967,010,812.14
Эргэлтийн бус хөрөнгө:			
Үндсэн хөрөнгө	9	3,875,288,622.95	6,005,858,849.60
Биег бус хөрөнгө	10	95,719,560.00	101,719,560.00
Биологийн хөрөнгө			
Урт хугацаат хөрөнгө оруулалт			
Хайгуул ба үнэлгээний хөрөнгө			
Хойшлогдсон татварын хөрөнгө			
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө			
Бусад эргэлтийн бус хөрөнгө			
Эргэлтийн бус хөрөнгийн дүн		3,971,008,182.95	6,107,578,409.60
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		7,892,439,837.40	9,074,589,221.74
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ			
Богино хугацаат өр төлбөр:			
Дансны өглөг	11	416,479,739.00	1,776,022,613.24
Цалингийн өглөг		-	-
Татварын өр	12	683,076,403.65	516,455,854.33
НДШ-ийн өглөг		-	35,316,190.67
Богино хугацаат тээл	13	4,896,794.94	206,039,855.80
Хүүний өглөг		62,699,806.14	78,288,027.58
Нөгдөл ангийн өглөг	14	-	-
Урьдчилж орсон орлого	15	182,871.60	8,586,804.97
Нөөц /өр төлбөр/			
Бусад богино хугацаат өр төлбөр		934,010.00	-
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө			
Богино хугацаат өр төлбөрийн дүн		1,168,269,625.33	2,620,709,346.59
Урт хугацаат өр төлбөр:			
Урт хугацаат тээл	16	2,338,372,478.35	2,113,011,320.19
Нөөц /өр төлбөр/			
Хойшлогдсон татварын өр			
Бусад урт хугацаат өр төлбөр			
Урт хугацаат өр төлбөрийн дүн		2,338,372,478.35	2,113,011,320.19
Өр төлбөрийн нийт дүн		3,506,642,103.68	4,733,720,666.78
Өмч:			
- төрийн			
- хувийн	17	53,617,700.00	53,617,700.00
- хувьцаат			
Халаасны хувьцаа			
Нэмж төлөгдсөн капитал			
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	18	4,363,888,720.07	4,363,888,720.07
Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц			
Эздийн өмчийн бусад хэсэг			
Хуримтлагдсан ашиг	19	(31,708,686.34)	(76,637,865.10)
Эздийн өмчийн дүн		4,385,797,733.73	4,340,868,554.97
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН		7,892,439,837.40	9,074,589,221.75

(0.00)

Тайлан нь дүнгээрийн салтгүй хэсэг болно



"ЭРЧИМБАЯН ӨЛГИЙ" ХК
АУДИТЛАСАН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН
 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил

		(Төгрөгөөр)	
	<i>Лав</i>	2023 он	2022 он
Цэвэр борлуулалтын орлого	20	6,513,409,736.93	5,069,532,242.02
Борлуулалтын өртөг	21	5,531,539,290.54	4,130,889,435.55
Нийт ашиг (алдагдал)		981,870,446.39	938,642,806.47
Түрээсийн орлого			
Хүүний орлого		-	-
Ногдол ашгийн орлого			
Эрхийн шимтгэлийн орлого			
Бусад орлого		66,857,053.64	6,054,545.45
Борлуулалт, маркетингийн зардал		-	-
Ерөнхий ба удирдлагын зардал	22	256,687,602.43	209,970,934.53
Санхүүгийн зардал	23	526,565,141.17	493,645,499.79
Бусад зардал	24	215,553,446.70	203,621,985.30
Гадаад валютын ханшийн зөрүүгийн олз (гарз)		-	(459,900.00)
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		-	635,833.24
Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)			
Хөрөнгө оруулалт борлуулалтаас үүссэн олз (гарз)			
Бусад ашиг (алдагдал)			
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)		49,921,309.73	37,634,865.54
Орлогын албан татварын зардал		4,992,130.97	3,763,486.55
Татварын дараах ашиг (алдагдал)		44,929,178.76	33,871,378.99
Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		-	-
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)		44,929,178.76	33,871,378.99
Бусад дэлгэрэнгүй орлого		-	-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн			
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү			
Бусад олз (гарз)		-	-
Орлогын нийт дүн		44,929,178.76	33,871,378.99
Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)			

Тайлан нь дүгээлтийн салшгүй хэсэг болно



"ЭРЧИМБАЯН ӨЛГИЙ" ХК
АУДИТЛАСАН ӨМЧИЙН ӨӨРЧӨЛТИЙН ТАЙЛАН
 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуслаар болсон тайлант жил

(Төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж товлосон капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Галанд валютын хөрвүүлэлтийн нөхцөл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2021 оны 12-р сарын 31-ний ҮЭЛЭГТЭЛ	53,617,700.00	-	-	-	-	-	(110,509,244.09)	(56,891,544.09)
Нягтлан болох бүртгэлийн боллогын өөрсөлтний нөлөө, алдааны залруулга								
Залруулсан үлдэгдэл	53,617,700.00	-	-	-	-	-	(110,509,244.09)	(56,891,544.09)
Тайлант үеийн цэвэр ашиг (аллагдал)							33,871,378.99	33,871,378.99
Бусад дэлгэрэнгүй орлого Өмчид гарсан өөрчлөлт Зарласан нэгдэл ашиг Дахин үнэлээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн				4,363,888,720.07				4,363,888,720.07
2022 оны 12-р сарын 31 -ний ҮЭЛЭГТЭЛ	53,617,700.00	-	-	4,363,888,720.07	-	-	(76,637,865.10)	4,340,868,554.97
Нягтлан болох бүртгэлийн боллогын өөрсөлтний нөлөө, алдааны залруулга								
Залруулсан үлдэгдэл	53,617,700.00	-	-	4,363,888,720.07	-	-	(76,637,865.10)	4,340,868,554.97
Тайлант үеийн цэвэр ашиг (аллагдал)							44,929,178.76	44,929,178.76
Бусад дэлгэрэнгүй орлого Өмчид гарсан өөрчлөлт Зарласан нэгдэл ашиг Дахин үнэлээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн								
2023 оны 12-р сарын 31 -ний ҮЭЛЭГТЭЛ	53,617,700.00	-	-	4,363,888,720.07	-	-	(31,708,686.34)	4,385,797,733.73

Тайлан нь дулиангийн санхүүг хэсэг болно



"ЭРЧИМБАЯН ӨЛГИЙ" ХК
АУДИТЛАСАН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН
 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил

	(Тогроогоор)	
	2023 он	2022 он
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	7,229,979,884.85	5,728,065,913.74
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	6,903,977,589.03	5,412,628,901.70
Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
Буцаан авсан албан татвар		
Татаас, санхүүжилтийн орлого		
Бусад мөнгөн орлого	326,002,295.82	315,437,012.04
Мөнгөн зарлагын дүн (-)	7,130,053,230.53	4,387,428,662.65
Ажилчдад төлсөн	1,025,486,391.11	769,195,948.13
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	354,667,759.87	223,567,968.00
Бараа материал худалдан авахад төлсөн	1,156,311,089.01	427,244,277.10
Ашиглалтын зардалд төлсөн	968,557,768.00	339,398,635.77
Түлш шатахуун, тээврийн хөлө, сэлбэг хэрэгсэлд төлсөн	966,785,411.24	1,061,096,388.22
Хүүний төлбөрт төлсөн	479,994,467.89	440,229,733.94
Татварын байгууллагад төлсөн	242,420,957.59	436,768,784.86
Даатгалын төлбөрт төлсөн	3,514,536.00	3,245,535.16
Бусад мөнгөн зарлага	1,932,314,849.82	686,681,391.47
Үндсэн үйл ажиллагааны нэвэр мөнгөн гүйлгээний дүн	99,926,654.32	1,340,637,251.09
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	49,387,966.25	-
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	49,387,966.25	
Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	-	-
Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	-	-
Хүлээн авсан хүүний орлого		
Хүлээн авсан ногдол ашиг		
Мөнгөн зарлагын дүн (-)	149,120,193.45	20,715,000.00
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	149,120,193.45	16,350,000.00
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	215,000.00
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-	2,200,000.00
Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	
Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	-	1,950,000.00
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны нэвэр мөнгөн гүйлгээний дүн	(99,732,227.20)	(20,715,000.00)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	1,000,000,000.00	25,240,000.00
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	1,000,000,000.00	25,240,000.00
Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
Төрөл бүрийн хандяв	-	-
Мөнгөн зарлагын дүн (-)	983,681,863.35	1,302,105,896.32
Зээл, өрийн үнэ цаасны төлбөрт төлсөн мөнгө	983,681,863.35	1,302,105,896.32
Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	-	-
Төлсөн ногдол ашиг		
Бусад		
Санхүүгийн үйл ажиллагааны нэвэр мөнгөн гүйлгээний дүн	16,318,136.65	(1,276,865,896.32)
Валютын ханшийн зөрүү	-	-
Бүх нэвэр мөнгөн гүйлгээ	16,512,563.77	43,056,354.77
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эзний үлдэгдэл	61,439,573.74	18,383,218.97
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эзсийн үлдэгдэл	77,952,137.51	61,439,573.74
	0.00	0.00

Тайлан нь дүгнэлтийн санхүүг хэсэг болно



01. КОМПАНИЙ ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

“Эрчимбаян Өлгий” ХК нь 1952 онд Дизель станц нэртэйгээр 54 квт-ын хүчин чадалтай цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх зориулалттай байгуулагдсан. 1965 онд Үйлдвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлж Чехословак улсын тусламжтайгаар турбинтай цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэх станцыг ашиглалтанд оруулж эрчим хүчний үйлдвэрийн захиргаа байгуулагдсан. 1986 онд ЗХУ-ын 48 Гкал/цаг хүчин чадалтай КЕ2514 маркын 3ш зуухтай дулааны станц ашиглалтанд орсноор аймагт дулаан болон цахилгааныг тус тусдаа үйлдвэрлэдэг Эрчим хүчний нэгдсэн үйлдвэр байгуулагдсан. 1997 онд ОХУ-ын өндөр хүчдэлд холбогдсоноор манай аймгийн цахилгаан эрчим хүчийг “баруун бүсийн эрчим хүчийн систем” Төрийн өмчид хувьцаат компани хангадаг болсноор Цахилгаан шугам сүлжээний газар, Эрчим хувьцаат компани болж тус тусдаа өөр өөрийн бие даасан статустай болсон.

2006 онд дулааны станцыг төрийн өмчийн хорооны шийдвэрээр дуудлага худалдаагаар худалдахад иргэн Дакейн Мурат 652 сая төгрөгөөр худалдаж авсан. Анх тус дулааны станцыг хувьчилж авхад 1,4 тэрбум төгрөгийн өртэй, тоног төхөөрөмж хуучирсан, шугам хоолой муудсан, хэрэглэгчдийг стандартын шаардлага хангасан эрчим хүчээр хангаж чадаагүй, хэрэглэгчдийн тоо эрс буурсан байдалтай байсан. Дулааны эрчим хүчийг шинэчлэх зайлшгүй шаардлагатай байсан учраас дулааны станцад эрс шинэчлэлт хийж өнөөгийн түвшинд хүргэсэн.

Тус компани нь Баян-Өлгий аймгийн төвийн А бүсэд байрлах байгууллага, аж ахйн нэгж, амины сууц болон нийтийн орон сууцны оршин суугчдын 98 хувийг дулааны эрчим хүчээр хангадаг томоохон компани болсон. 2022 онд 106 ажилчидтайгаар үйл ажиллагаагаа явуулсан.

Компани нь Монгол Улсын Эрчим Хүчний Зохицуулах Хорооноос дараах Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлүүдийг авч ажиллаж байна.

№	Олгосон огноо	Т/З-ийн дугаар	Эрхлэх үйл ажиллагааны төрөл	Үйлчлэх хүрээ	Тусгай зөвшөөрлийн хугацаа
1	2020-10-08	24/2015	Дулаан үйлдвэрлэх	Баян-Өлгий аймгийн Өлгий сумын төвлөрсөн дулаан хангамжийн системд	5 жил
2	2020-10-08	25/2015	Дулаан түгээх	Баян-Өлгий аймгийн Өлгий сумын нутаг дэвсгэрт “Эрчимбаян-Өлгий”ХК-ийн эзэмшлийн дулаан түгээх сүлжээнд холбогдсон хэрэглэгчид	5 жил

Санхүүгийн Тайлангийн Тодруулга 2023.12.31

3	2020-10-08	26/2015	Дулаанаар зохицуулалттай хангах	Баян-Өлгий аймгийн Өлгий сумын нутаг дэвсгэрт “Эрчимбаян-Өлгий”ХК-ийн эзэмшлийн дулаан түгээх сүлжээнд холбогдсон хэрэглэгчид	5 жил
---	------------	---------	---------------------------------	---	-------

Мөн Увс аймгийн Бөхмөрөн сумын Нүүрст хотгор нэртэй газарт 29 га талбайд ашигт малтмал ашиглалтын 5696А тусгай зөвшөөрлийг 0210001004 тоот гэрчилгээтэй Эрчимбаян Өлгий ХК эзэмшдэг.

2006 оны 07-р сарын 04-ний өдөр уур үйлдвэрлэл, халуун ус хангамж, цахилгаан үйлдвэрлэх, дамжуулах, хуваарилах үйл ажиллагаа, ашигт малтмал ашиглах чиглэлээр 0210001004 тоот улсын бүртгэлийн дугаартай, 2003821 регистрийн дугаар бүхий Улсын Бүртгэлийн Гэрчилгээ авсан. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 536,177 ширхэг энгийн хувьцаа буюу 56,617,700 төгрөгнөөс бүрддэг. Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвийн 2022 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн үнэт цаас эзэмшигчдийн судалгаагаар 2 хувьцаа эзэмшигч нийт хувьцааны 93.2 хувийг эзэмшиж, 6.8 хувь нь жижиг хувьцаа эзэмшигчид байна.

02. САНХҮҮГИЙН ТАЙЛАН БЭЛТГЭХ ҮНДЭСЛЭЛ, СУУРЬ

Компаний хувьцаа эзэмшигчид компаний өр төлбөрийг барагдуулах хангалттай мөнгөн хөрөнгөтэй байлгахыг хүлээн зөвшөөрдөг учраас компани санхүүгийн тайлангаа тасралтгүй байх зарчмын дагуу бэлтгэдэг. Компани нь дуудлага худалдаагаар хувьчлагдсан 2006 оноос дамжин ирсэн хуримтлагдсан өр төлбөр, хуримтлагдсан алдагдалтай байсан боловч сүүлийн жилүүдэд ашигтай ажиллаж, хуримтлагдсан алдагдал, өр төлбөрөө төлж, техник тоног төхөөрөмжөө шинэчлэн ажилласнаар эздийн өмчийн нийт дүн 4.3 тэрбум төгрөг болсон нь цаашид компаний үйл ажиллагаа тасралтгүй үргэлжлэнэ гэсэн төсөөлөл дээр санхүүгийн тайланг бэлтгэсэн.

Санхүүгийн тайлан бэлтгэх үндсэн зарчим

Компани санхүүгийн тайлангаа Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (цаашид СТОУС гэх), Олон улсын санхүүгийн тайлагналын стандартын Тайлбарын байнгын хорооноос баталсан тайлбар, Монгол Улсын холбогдох хууль, тогтоомж болон Сангийн яамнаас баталсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны жагсаалт, дансны үлгэрчилсэн заавар”, “Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан бэлтгэж, гаргах аргачлал”-ын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан бэлтгэдэг.

Үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг бэлтгэсэн валют

Компанийн үйл ажиллагааны үндсэн валют нь Монгол Улсын мөнгөн тэмдэгт “төгрөг” юм. Хавсаргасан санхүүгийн тайланг төгрөгөөр бэлтгэсэн.

03. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ОНЦЛОХ БОДЛОГУУД

1. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгөн гүйлгээний тайлангийн зорилгоор мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө нь касс дахь бэлэн мөнгө ба банкин дахь харилцах дансуудаас бүрддэг. Мөнгөн хөрөнгийг бэлнээр эсвэл банкинд байлгах нь ямар нэг эрсдэл агуулахгүй. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийг нэрлэсэн үнээр нь бүртгэдэг. Гадаад валютаархи мөнгөн хөрөнгийг Монголбанкнаас зарласан албан ханшаар төгрөгт шилжүүлж бүртгэдэг.

2. Борлуулалтын ба бусад авлагууд

Борлуулалтын болон бусад авлагуудыг анх бүртгэхдээ нэрлэсэн үнээр нь бүртгэх бөгөөд найдваргүй авлагыг бүртгэх шууд данснаас хасах аргын дагуу авлагыг найдваргүй нь нотлогдсон үед найдваргүй авлагын зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэх ба найдваргүй болсон авлагын дүнгээр дансны авлагыг бууруулна.

3. Бараа материал

Компаний бараа материалд бизнесийн хэвийн үйл ажиллагааны явцад худалдан борлуулахаар эзэмшиж байгаа хөрөнгө, эсвэл үйлчилгээ үзүүлэхэд ашиглах гэж байгаа материал болон хангамжийн зүйлс хэлбэрээр байгаа хөрөнгө орно.

Бараа материалын өртөгт худалдан авалтын өртөг, хувиргалтын зардал болон одоогийн байршил ба нөхцөлд бараа материалыг авчрахтай холбоотой гарсан зардал орно. Худалдан авалтын өртөг нь худалдан авсан үнэ, гаалийн татвар, хураамж, тээврийн зардал, бусад холбогдох зардлуудаас бүрдэнэ.

Цэвэр боломжит үнэ цэнэ нь байгууллагын тодорхойлсон үнэ байдаг бол бодит үнэ цэнэ нь холбоогүй талуудын ажил гүйлгээгээр зохих мэдлэгтэй, арилжаанд оролцоход бэлэн байгаа талуудын хооронд хөрөнгийг солилцох, эсвэл өр төлбөрөөр тооцож болох дүн юм.

4. Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн анхны өртөг нь худалдаж авсан үнэ, импортын татвар, нөхөн олгохгүй худалдан авалтын бусад татварууд болон хөрөнгийг байршуулах, зориулалтаар нь ашиглахад бэлэн болгохтой шууд холбоотой гарах зардлаас бүрддэг. Үндсэн хөрөнгийг ашиглалтанд оруулснаас хойш гарсан зардлуудыг тухайлбал засвар үйлчилгээний зардлыг тухайн зардал гарсан жилийн үр дүнгийн тайланд тусгадаг. Харин тухайн зардал гарснаар хөрөнгийг анх авах үеийн тооцоолсон бүтээмж нэмэгдэж, хөрөнгөөс олох эдийн засгийн ирээдүйн үр өгөөжийг нэмэгдүүлсэн нь тодорхой батлагдаж байвал гарсан зардлыг хөрөнгийн өртөг дээр нэмж капиталжуулна. Үндсэн хөрөнгийн үнэ цэнийг тогтмол хянаж, НББОУС-16-ын дагуу дансны үнэ, балансын өдрөөрхи бодит үнэ цэнийн хооронд материаллаг зөрүү гарсан нөхцөлд дахин үнэлгээ хийдэг.

Дахин үнэлгээний нэмэгдлийг дахин үнэлгээний нөөц дансанд тусгана. Харин дахин үнэлгээний бууралтыг тухайн хөрөнгийн хувьд үүссэн өмнөх жилийн нэмэгдлийн дүнг тэг

Санхүүгийн Тайлангийн Тодруулга 2023.12.31

болтол дахин үнэлгээний нөөц дансыг бууруулна. Бусад бүх тохиолдолд дансны үнийн бууралтыг орлогын тайланд тусгана.

Үндсэн хөрөнгийн элэгдлийг тухайн хөрөнгийг ашиглах боломжтой болсон үеэс эхэлж байгуулдаг ба стандартын дагуу шулуун шугамын арга, үлдэгдлийг буруулах арга, бүтээгдэхүүний нэгжийн аргуудаас ашиглаж болох хэдий ч Монгол улсын аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн дагуу шулуун шугамын аргаар элэгдэл тооцож байгуулдаг, үндсэн хөрөнгийн элэгдүүлэх хугацаа дараах байдалтай байна.

№	Үндсэн хөрөнгийн бүлэг	Татварын хуулиар	Компаний хувьд
		Ашиглах хугацаа (жилээр)	Ашиглах хугацаа (жилээр)
1.	Барилга, байгууламж	25	40
2.	Машин, механизм, техник, тоног төхөөрөмж	10	10
3.	Компьютер, түүний эд анги, программ хангамж	2	2
4.	Бусад үндсэн хөрөнгө	10	10

Үндсэн хөрөнгийг данснаас хасахдаа үлдэгдэл өртгийн дүнгээр хөрөнгө данснаас хассаны гарзыг, худалдан борлуулах үед хөрөнгийн үлдэгдэл өртөг, худалдсан үнийн зөрүүгээр хөрөнгө худалдан борлуулсны олз, гарзыг хүлээн зөвшөөрдөг.

5. Дансны ба бусад өглөг

Дансны болон бусад өглөгийг анх бүртгэхдээ нэрлэсэн үнээр нь бүртгэдэг бөгөөд дараагийн тайлант хугацаа бүрт хөнгөлөлт нь материаллаг биш бол өртөг болж, өглөгийг хорогдуулан бүртгэнэ.

6. Хувьцаат капитал

Энгийн хувьцаа

Энгийн хувьцааг өөрийн хөрөнгөөр ангилна. Энгийн хувьцаа гаргахтай шууд холбоотой гарсан зардлуудыг татварыг нь суутгасан цэвэр дүнгээр өөрийн хөрөнгийг бууруулан бүртгэдэг. Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасны дагуу компанийн хувьцаа нь компанид хөрөнгө оруулж, түүнийг үндэслэн санал санал өгөх, ногдол ашиг авах, компанийг татан буулгасны дараа үлдсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогоос хувь хүртэх зэрэг хувьцаа эзэмшигчийн эрхийг гэрчилнэ.

Халаасны хувьцаа

Өөрийн хөрөнгөөр бүртгэсэн энгийн хувьцааг эргүүлэн худалдан авахдаа төлсөн, ийнхүү худалдан авахтай холбоотой гарсан бүх зардлуудыг, татварыг нь хассан цэвэр дүнгээр өөрийн хөрөнгийг бууруулан бүртгэдэг. Эргүүлэн худалдан авсан хувьцааг халаасны

хувьцаагаар ангилах ба нийт өөрийн хөрөнгийн бууралт байдлаар харуулдаг. Харин халаасны хувьцааг дахин гаргасан, худалдсан бол хүлээн авсан мөнгөн дүнгээр өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх ба тухайн гүйлгээнээс бий болсон илүү ба дутуугийн зөрүүг хуримтлагдсан ашгаас нөхөх эсвэл ашгийг нэмэгдүүлэх байдлаар залруулдаг.

7. Орлого хүлээн зөвшөөрөх

Орлогыг хүлээн авсан эсвэл хүлээн авахаар хүлээгдэж буй төлбөрийн бодит үнэ цэнээр бүртгэнэ. Орлогод зөвхөн тухайн бизнесийн үйл ажиллагаанаас хүлээн авсан болоод ирээдүйд хүлээн авах эдийн засгийн өгөөжийн дотогш урсгал хамаарна. Суутгасан татвар, барааны болон үйлчилгээний хураамж, нэмэгдсэн өртгийн татвар зэрэг гуравдагч талын өмнөөс цуглуулсан дүн нь аж ахуйн нэгжийн эдийн засгийн өгөөжид хамаарахгүй бөгөөд эзэмшигчдийн өмчийг нэмэгдүүлэхгүй. Иймээс эдгээрийг орлогын дүнгээс хасч тооцдог.

Компани тайлант хугацаанд үйлдвэрлэж, хэрэглэгчдээс нэхэмжилсэн дулааны үнийг борлуулалтын орлогод бүртгэдэг бөгөөд борлуулалтын орлогыг хүлээн авсан буюу хүлээн авахаар хүлээгдэж буй мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн нэрлэсэн үнээр хэмжиж, тайлагнадаг. Хэрэглэгчдэд нийлүүлсэн дулааны эрчим хүчний борлуулалтын үнийг Эрчим хүчний зохицуулах газраас тогтоодог.

8. Гадаад валютын хөрвүүлэлт

Санхүүгийн тайланг төгрөгөөр илэрхийлсэн бөгөөд компани үйл ажиллагаагаа явуулдаг албан ёсны мөнгөн тэмдэгт нь Монгол улсын мөнгөн тэмдэгт төгрөг юм. Гадаад валютаар хийгдсэн ажил гүйлгээг тухайн валютаар болон гүйлгээ хийгдэх үеийн Монголбанкнаас зарласан албан ханшаар төгрөгт шилжүүлэн, төгрөг/валютаар давхар бүртгэдэг. Гадаад валютаархи мөнгөн хөрөнгө, тооцооны дансыг балансын дуусгавар болсон өдрийн албан ханшаар төгрөгт шилжүүлэн бүртгэсэн. Гадаад валютаар хийгдсэн ажил гүйлгээнээс үүссэн зөрүүг орлогын тайланд тусгагддаг. Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн бус зүйлсийг түүхэн өртгөөр нь тооцож, тухайн ажил гүйлгээ анх гарсан өдрийн ханшаар хөрвүүлэн бүртгэдэг. Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн бус зүйлсийг нэрлэсэн үнээр нь бүртгэдэг бөгөөд нэрлэсэн үнийг тогтоосон өдрийн ханшаар хөрвүүлэн балансад тусгадаг.

9. Ажилчдын тэтгэвэр, тэтгэмж

Ажилчдын богино хугацааны тэтгэмжид цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл, ээлжийн амралтын цалин, өвчтэй хугацааны тэтгэмж, арван хоёр сарын дотор төлөгдөх ашгийн хувиарлалт, шагналын өглөг болон мөнгөн бус тэтгэмжүүд болох эмнэлгийн үйлчилгээ, байрны хөлс, унааны хөлс, үнэгүй буюу хөнгөлөлттэй бараа үйлчилгээ ордог.

10. Орлогын албан татвар

Тайлант үеийн татвар гэдэгт тайлант үеийн татвар ногдуулах ашиг (алдагдал)-аас тооцсон орлогын албан татварын өглөгийн дүн болон хойшлогдсон татварын өглөг эсвэл хойшлогдсон татварын хөрөнгөөс бүрддэг. Тайлант жилийн татвар нь тухайн жилийн орлогоос хуулийн дагуу тогтоосон татварын хувиар ногдуулсан татварын өглөгийн дүн юм.

Хойшлогдсон татварын хөрөнгө болон татварын өглөг нь санхүүгийн байдлын тайлан дахь хөрөнгө, эсвэл өр төлбөрийн дансны үнэ ба татварын суурь хоёрын хоорондох зөрүүнээс үүсдэг. Түр зөрүү нь хоёр хэлбэртэй бөгөөд эдгээр нь зэрэг тодорхойлогдоггүй, аль нэг нь л байна. Үүнд:

- *татвар ногдох түр зөрүү* гэдэг нь хөрөнгө эсвэл өр төлбөрийн дансны үнийг нөхөх эсвэл барагдуулах үед ирээдүйн тайлант үеийн татвар ногдуулах ашиг (татварын алдагдал)-ыг тодорхойлоход татвар ногдох орлогод үүсэх түр зөрүү юм.
- *хасагдах түр зөрүү* гэдэг нь хөрөнгө эсвэл өр төлбөрийн дансны үнийг нөхөх эсвэл барагдуулах үед ирээдүйн татвар ногдуулах ашиг (татварын алдагдал)-ыг тодорхойлоход татвар ногдох орлогоос хасагдах дүнгээс үүсэх түр зөрүү юм.

04. НИЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ БА ТООЦООЛОЛ

Компаний удирдлага санхүүгийн тайлан бэлтгэхэд тайлант үеийн орлого, зардал, хөрөнгө болон өр төлбөрүүдэд нөлөөлөхүйц үнэлгээ, тооцоолол, таамаглалыг боловсруулах шаардлагатай тулгардаг. Эдгээр таамаг тооцооны эргэлзээтэй дүнг ирээдүйн хөрөнгө ба өр төлбөрт нөлөөлөхүйц материаллаг бол тохируулах бичилт хийдэг.

а) Тооцооллын эх үүсвэр

Санхүүгийн тайлангийн өдрөөрхи ирээдүйн үйл ажиллагааны тухай авч үзэж байгаа гол тооцоолол болон эргэлзээтэй тооцооллын эх үүсвэр нь дараагийн тайлант жилд уг хөрөнгийн дүнд материаллаг тохируулах бичилт хийх эрсдэл бий болоход нөлөөлдөг. Ирээдүйд нөлөөлж болох тооцооллыг доор тайлбарлав.

Барилга, тоног төхөөрөмжийн элэгдэл

Барилга, тоног төхөөрөмжийг тэдгээрийн ашиглалтын хугацаанд үндэслэн шулуун шугамын аргаар элэгдүүлдэг. Барилга, тоног төхөөрөмжийн ашиглалтын хугацааг аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хуулийн дагуу 10-аас 40 жилийн хооронд байна гэж удирдлага үздэг. Ашиглах хугацаа, технологийн дэвшилээс үүдэн тооцоолсон ашиглах хугацааны өөрчлөлт нь ашиглах хугацааны хэмнэлт болон эдгээр хөрөнгийн үлдэх өртөгт нөлөөлдөг тул дараагийн жилүүдийн элэгдлийн зардлыг дахин хянах шаардлагатай байдаг.

б) Хөрөнгийн үнэ цэнийн бууралт

Компани нь хөрөнгийн үнэ цэнэ буурч болзошгүй болохыг илтгэх шинж тэмдэг байгаа эсэхийг тайлант үе бүрийн эцэст үнэлэх хэрэгтэй. Хэрэв ийм ямар нэг шинж тэмдэг илэрвэл компани хөрөнгийн нөхөгдөх дүнг тооцоолох ёстой. Нөхөгдөх дүн нь хөрөнгө эсвэл хөрөнгө бий болгогч нэгжийн бууруулах зардлыг хассан болит үнэ цэнэ ба ашиглалтын үнэ цэнийн аль их нь байна.

е) Хойшлогдсон татварын хөрөнгийг хүлээн зөвшөөрөх

Хэрэглээгүй татварын алдагдал, татварын өглөг болон хасагдах түр зөрүүгээс үүссэн хойшлогдсон татварын хөрөнгийг хүлээн авахаар тооцоолсон дүнгээр хэмжиж, бүртгэдэг. Ашиглаж байгаа татварын хувь нь хуулийн дагуу байх ба балансын хугацаанд хүчин төгөлдөр мөрдөгдсөн байна. Хойшлогдсон хөрөнгийн дүнг тооцоолохдоо, хүлээгдэж байгаа татварын ашгийг компаний үйл ажиллагааны нөхцөлтэй уялдуулан тооцооллыг гаргах ба удирдлагын заавар журмын дагуу гүйцэтгэх шаардлагатай. Уг тооцооллын ямар нэг өөрчлөлтийг хойшлогдсон татварын хөрөнгөөр бүртгэж, дараагийн жилүүдэд ашгаар тусгана.

д) Нэмэгдсэн өртгийн албан татварын тооцоолол

Компанийн импортолсон буюу экспортолсон бараа, үйлдвэрлэсэн буюу борлуулсан бараа, гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээнд нэмэгдсэн өртгийн албан татвар ногдуулна. Тус компани одоогоор экспортод бараа, бүтээгдэхүүн гаргаагүй, экспортод гаргасан бараа, ажил, үйлчилгээний нэмэгдсэн өртгийн албан татварын хувь, хэмжээ тэг хувьтай тэнцүү байна. Харин импортолсон, үйлдвэрлэсэн, борлуулсан бараа, гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээний хувьд албан татвар тооцох үнэлгээний 10 хувиар ногдуулна.

Орлого, зардал болон хөрөнгө нь нэмэгдсэн өртгийн албан татварыг хасч цэвэр дүнгээр тусгагдаг бол авлага ба өглөгийг балансад тусгахдаа НӨАТ багтсан дүнгээр тусгадаг. Татварын байгууллагаас буцаан авах НӨАТ болон төлөх дүн нь балансын хэсэгт авлага, өглөгөөр тусад нь тусгадаг.

е) Нэгж хувьцаанд ногдох ашиг

Тусдаа санхүүгийн тайлан бэлтгэдэг аж ахуйн нэгж нь зөвхөн орлогын тайландаа нэгж хувьцаанд ногдох ашгийн мэдээллийг тусгана. Нэгж хувьцаанд ногдох суурь ашгийг тооцоолоход энгийн хувьцааны тоо нь тайлангийн хугацаанд эргэлтэнд байсан энгийн хувьцааны жинлэсэн дундаж тоо байна.

ф) Ажилчдын тэтгэвэр тэтгэмж, нийгмийн даатгалын шимтгэл

Ажилчдын тэтгэмж гэдэгт ажилчдын аж ахуйн нэгжид үзүүлсэн үйлчилгээний хариу болгон аж ахуйн нэгжийн зүгээс олгож буй бүх төрлийн халамж, шагнал юм.

Тогтоосон шимтгэлийн төлөвлөгөө гэдэг нь ажил олгогч аж ахуйн нэгж өөр нэг тусдаа аж ахуйн нэгж (сан)-д тогтмол шимтгэлийг төлөх бөгөөд хэрэв уг сан нь ажилчдын одоогийн болон өнгөрсөн хугацаанд холбогдох тэтгэмжүүдийг төлөхөд хүрэлцэхүйц хөрөнгөтэй байвал ажил олгогч цаашид тэтгэмжийн төлбөрийг үргэлжлүүлэн төлөх хууль зүйн болон үүсмэл үүрэг хүлээгэдтгүй ажил эрхлэлтийн дараах тэтгэмжийн төлөвлөгөө юм.

Монгол Улсын Нийгмийн даатгал болон Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн дагуу ажиллагчдад олгосон цалин, түүнтэй адилтгах орлогод даатгуулагч 11.5 хувиар, ажил олгогч 13.5 хувиар тооцож нийгмийн даатгал болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлдөг. Ажил олгогчийн шимтгэлийг төлөхөөр хуримтлуулан дэлгэрэнгүй орлогын тайланд тусган харуулдаг.

Санхүүгийн Тайлангийн Тодруулга 2023.12.31

Компани нь нийгмийн даатгалын системд ажил олгогчоос төлдөг нийгмийн даатгалын шимтгэлийн төлбөрөөс өөр тэтгэвэрт гарах үсний тэтгэмжийг олгодоггүй.

г) Хувь хүний орлогын албан татвар

Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн дагуу ажил олгогч тухайн ажилтаны цалингийн орлогоос 10 хувь суутган тооцож төсөвт шилжүүлэн төлдөг.

Санхүүгийн Тайлангийн Тодруулга 2023.12.31

04. МӨНГӨН ХӨРӨНГӨ

Мөнгөн хөрөнгө нь касс дахь бэлэн мөнгө, харилцах дансан дахь мөнгөнөөс бүрдэж байгаа бөгөөд ямар нэгэн хязгаарлалт хийгдээгүй. 2022 он болон 2023 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Мөнгөн хөрөнгө дараах байдалтай байна.

	Валют	Дансны дугаар	2023 он		2022 он	
			Төгрөг		Төгрөг	
Касс төгрөг	Төгрөг		16,993,461.00	30,184,363.38		
	Кассын дүн		16,993,461.00	30,184,363.38		
ХААН БАНК	Төгрөг	5180239579	28,923,375.13	11,009,811.72		
ТӨРИЙН БАНК	Төгрөг	291400185197	8,167,601.43	6,646,637.69		
КАПИТРОН БАНК	Төгрөг	3005004553	7,412,475.42	1,083,863.42		
ХАСБАНК	Төгрөг	5001042675	15,427,743.16	6,731,695.76		
ХАСБАНК	Рубль	5002797209	19,603.89	19,603.89		
ГОЛОМТ БАНК	Төгрөг	5805000211	387,956.25	1,116,551.92		
ГОЛОМТ БАНК	Рубль	5805116768	19,069.65	19,069.65		
ГОЛОМТ БАНК-посс	Төгрөг	5805107577	570,851.58	4,627,976.31		
			30,000.00			
	Харилцахын дүн		60,958,676.51	31,255,210.36		
	НИЙТ ДҮН		77,952,137.51	61,439,573.74		

Санхүүгийн Тайлангийн Тодруулга 2023.12.31

05. ДАНСНЫ АВЛАГА

2022 он болон 2023 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Дансны авлага дараах байдалтай байна.

	2023 он	2022 он
Дансны авлага- Аж ахуйн нэгж	107,874,820.68	106,953,228.25
Дансны авлага- Төсөвт байгууллага	2,223,616,714.43	1,677,993,188.43
Дансны авлага- Айл өрх	80,963,987.80	107,119,529.09
НИЙТ ДҮН	2,412,455,522.91	1,892,065,945.77

Тайлант онд нийт дансны авлагын 66.1% буюу нийт 1,595,004.6 мянган төгрөгт тооцоо нийлсэн акт үйлдэж үлдэгдлийг баталгаажуулсан байна.

06. БУСАД АВЛАГА

2022 он болон 2023 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Бусад авлага дараах байдалтай байна.

	2023 он	2022 он
Ажитгнаас авах авлага	49,490,679.98	57,009,249.93
Харилцагч байгууллагаас авах авлага	1,111,500.00	-
Дараа тайлангын авлага	20.32	181,491.50
Бусад авлага	681,502,904.82	269,653,601.53
Дансны авлага - Хутгы-Мекен	46,670.00	-
НИЙТ ДҮН	732,151,775.12	326,844,342.96

Санхүүгийн Тайлангийн Тодруулга 2023.12.31

07. БАРАА МАТЕРИАЛ

2022 он болон 2023 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Бараа материал дараах байдалтай байна.

	2023 он	2022 он
Бараа материал	88,000.00	88,000.00
Маркетингийн эд зүйлс	1,313,500.00	1,313,500.00
Ашиглалтанд байгаа материал	206,000.00	206,000.00
Сэлбэг хэрэгсэл	537,455,977.17	326,031,579.87
Бичиг хэргийн материал	4,864,800.00	836,750.00
Хөдөлмөр хамгааллын материал	33,019,929.00	11,023,650.00
Шатах тослох материал	16,294,500.00	6,065,478.00
Нүүрс	24,837,300.00	310,758,912.00
Бусад хангамжийн материал	3,110,900.00	12,388,000.00
Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс	4,488,014.50	4,252,739.50
НИЙТ ДҮН	625,678,920.67	672,964,609.37

08. УРЬДЧИЛЖ ТӨЛСӨН ЗАРДАЛ, ТООЦОО

2022 он болон 2023 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Урьдчилж төлсөн зардал, тооцоо дараах байдалтай байна.

	2023 он	2022 он
Урьдчилж төлсөн зардал	73,162,620.00	13,696,340.00
НИЙТ ДҮН	73,162,620.00	13,696,340.00

Санхүүгийн Тайлангийн Толруулга 2023.12.31

09. ҮНДСЭН ХӨРӨНГӨ

2023 оны байдлаар компанийн Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн дараах байдалтай байна.

Үзүүлэлт	Барьцаа байгууламж	Машины механизм	Тээврийн хэрэгсэл	Тавигдсан эд хосшил	Компанийн, досгодогч хэрэгсэл	Нийт дүн
Өргөг						
2022 оны 12 сарын 31	7,034,263,509.63	1,332,918,580.08	307,584,941.75	99,427,819.34	12,192,500.00	8,786,387,350.80
Нэмэгдсэн	63,381,381.84	23,512,018.62	7,909,745.00	34,985,148.00	19,331,900.00	149,120,193.46
Хасалдсан	1,823,746,265.24	132,000.00	5,000,000.00	635,000.00	-	1,829,513,265.24
2023 оны 12 сарын 31	5,273,898,626.23	1,356,298,598.70	310,494,686.75	133,777,967.34	31,524,400.00	7,105,994,279.02
Хуримтлагдсан элэгдэл						
2022 оны 12 сарын 31	1,716,795,861.50	896,746,938.31	120,546,001.65	39,819,509.74	6,620,170.00	2,780,528,501.20
Нэмэгдсэн	366,283,681.20	49,824,986.39	19,916,342.02	9,711,455.31	4,440,689.95	450,177,154.87
Хасалдсан	-	-	-	-	-	-
2023 оны 12 сарын 31	2,083,079,542.70	946,571,944.70	140,462,343.67	49,530,965.05	11,060,859.95	3,230,705,656.07
Үлээгдэл өргөг						
2023 оны 12 сарын 31	3,190,819,083.53	409,726,654.01	170,032,343.08	84,247,002.28	20,463,540.05	3,875,288,622.95

Компанийн үл хөдлөх хөрөнгүүд нь 2023 оны 12 сарын 31-ны өдрийн байдлаар Голомт банкнаас авсан урт болон богино хугацаат эзэлийн барьцаа хөрөнгөнд байршуулсан байна.

Санхүүгийн Тайлангийн Тодруулга 2023.12.31

10. БИЕТ БУС ХӨРӨНГӨ

2023 оны байдлаар компанийн Биет бус хөрөнгийн хөдөлгөөн дараах байдалтай байна.

<i>Үзүүлэлт</i>	<i>Патент</i>	<i>Нийт дүн</i>
Өртөг		
2022 оны 12 сарын 31	136,000,000.00	136,000,000.00
Нэмэгдсэн	-	-
Хасагдсан	-	-
2023 оны 12 сарын 31	136,000,000.00	136,000,000.00
Хуримтлагдсан элэгдэл		
2022 оны 12 сарын 31	34,280,440.00	34,280,440.00
Тайлант жилийн хорогдол	6,000,000.00	6,000,000.00
2023 оны 12 сарын 31	40,280,440.00	40,280,440.00
Үлдэгдэл өртөг		
2023 оны 12 сарын 31	95,719,560.00	95,719,560.00
2022 оны 12 сарын 31	101,719,560.00	101,719,560.00

11. ДАНСНЫ ӨГЛӨГ

2022 он болон 2023 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Дансны өглөг дараах байдалтай байна.

	2023 он	2022 он
Дансны өглөг	181,913,496.00	375,255,867.41
Сэлбэгийн өглөг	102,810,466.00	96,173,334.48
Хөдөлмөр хамгаалалтын өглөг	3,271,800.00	10,768,161.50
Нүүрсний өглөг	24,837,300.00	554,579,351.71
Шатах тослох материалын өглөг	-	225,676,216.00
Хангамжийн материал	856,650.00	5,433,660.34
Тээврийн хөлсний өглөг	102,279,717.00	199,273,387.60
Хувь хүмүүст өгөх өглөг	510,310.00	308,862,634.20
НИЙТ ДҮН	416,479,739.00	1,776,022,613.24

Санхүүгийн Тайлангийн Тодруулга 2023.12.31

12. ТАТВАР ШИМТГЭЛИЙН ӨГЛӨГ

2022 он болон 2023 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Татвар, шимтгэлийн өглөг дараах байдалтай байна.

	2023 он	2022 он
ААНОАТ-ын өглөг	4,992,130.97	-
НӨАТ-ын өглөг	614,680,280.77	455,725,589.48
ХХОАТ-ын өглөг	26,791,811.00	20,528,687.18
Бусад өглөг	60,000.00	-
ҮХЭХАТ-ын өглөг	4,400,000.00	60,000.00
ГТ өглөг	6,414,330.00	-
АМНАТ өглөг	25,704,930.91	26,620,136.27
АБТ өглөг	920.00	44,520.00
АТБӨЯХАТ-ын өглөг	32,000.00	50,000.00
АТ-ын өглөг	-	13,426,921.40
НДШ-ийн өглөг	-	35,316,190.67
НИЙТ ДҮН	683,076,403.65	551,772,045.00

13. БОГИНО ХУГАЦААТ ЗЭЭЛ БА ХҮҮНИЙ ӨГЛӨГ

2022 он болон 2023 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Богино хугацаат зээл болон зээлийн хүүний өглөг дараах байдалтай байна.

	2023 он	2022 он
Богино хугацаат зээл /Голомт банк - ЗГ5805116785/	4,896,794.94	153,846,153.86
Богино хугацаат зээл - Урт хугацаат зээлээс ангилан бүртгэсэн	-	52,193,701.94
Богино хугацаат зээлийн хүү	62,699,806.14	78,288,027.58
НИЙТ ДҮН	67,596,601.08	284,327,883.38

Голомт банкны 2021 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн ЗГ5805116785 тоот зээлийн гэрээгээр 500.0 сая төгрөгийн зээлийг жилийн 16.8 хувь, 26 сарын хугацаатайгаар репо санхүүжилтийн зориулалтай олгосон. Зээл, зээлийн хүү банкнаас гаргасан графикийн дагуу төлөгдөж байна.

Санхүүгийн Тайлангийн Тодруулга 2023.12.31

14. УРЬДЧИЛЖ ОРСОН ОРЛОГО

2022 он болон 2023 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Урьдчилж орсон орлого дараах байдалтай байна.

	2023 он	2022 он
Урьдчилж орсон орлого	182,871.60	8,586,804.97
НИЙТ ДҮН	182,871.60	8,586,804.97

15. БУСАД БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР

2023 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Бусад богино хугацаат өр төлбөрийн дүн 934,010.00 /Есөн зуун гучин дөрвөн мянган арван/ төгрөг байна.

16. УРТ ХУГАЦААТ ЗЭЭЛ

2022 он болон 2023 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Урт хугацаат зээл дараах байдалтай байна.

	2022 он	2021 он
Голомт банк-ЗГ5805108428	1,592,218,632.19	3,477,987,862.95
Богино хугацаат зээл /Голомт банк - ЗГ5805114079/	520,792,688.00	-
НИЙТ ДҮН	2,113,011,320.19	3,477,987,862.95

Голомт банкны 2018 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн ЗГ5805108428 тоот зээлийн гэрээгээр 5.0 тэрбум төгрөгийн зээлийг жилийн 20.4 хувь, 60 сарын хугацаатайгаар хөрөнгө оруулалтын зориулалтай олгосон. Хөнгөлттэй хүүгийн жилийн хувь 19.2 хувь, 2023 оны 5 дугаар сарын 01-ний өдөр хүртэл үйлчилнэ. Зээл, зээлийн хүү банкнаас гаргасан графикийн дагуу төлөгдөж байна. Тайлант хугацааны урт хугацаатай зээлийн үлдэгдэл 1,592,218,632.19 төгрөг болно.

Голомт банкны 2020 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн ЗГ5805114079 тоот зээлийн гэрээгээр 1.0 тэрбум төгрөгийн зээлийг жилийн 19.2 хувь, 60 сарын хугацаатайгаар хөрөнгө оруулалтын зориулалтай олгосон. Зээл, зээлийн хүү банкнаас гаргасан графикийн дагуу төлөгдөж байна. Тайлант хугацааны урт хугацаатай зээлийн үлдэгдэл 520,792,688.00 төгрөг болно.

Голомт банкны 2023 оны 6 дугаар сарын ...-ны өдрийн ЗГ5805125091 тоот зээлийн гэрээгээр 1.0 тэрбум төгрөгийн зээлийг жилийн 19.2 хувь, 60 сарын хугацаатайгаар хөрөнгө оруулалтын зориулалтай олгосон. Зээл, зээлийн хүү банкнаас гаргасан графикийн дагуу төлөгдөж байна. Тайлант хугацааны урт хугацаатай зээлийн үлдэгдэл 719,557,015.56 төгрөг болно.

Санхүүгийн Тайлангийн Тодруулга 2023.12.31

17. ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧ

Компани нь нэг бүр нь 100 төгрөгийн үнэтэй 536,177 ширхэг энгийн хувьцаа буюу 53,617,700.00 төгрөгийн дүрмийн сантай бөгөөд иргэн Д.Мурат нь 78.5 хувийг, иргэн М.Тилеуберди нь 14.7 хувийг, Бусад жижиг хувьцаа эзэмшигчид үлдсэн 6.8 хувийг тус тус эзэмшдэг.

Эзэмшигчдийн нэр	Хувьцааны тоо	Нэг бүрийн үнэ /төгрөг/	Нийт дүн	Эзэмшлийн хувь
Д. МУРАТ	421,148.00	100	42,114,800.00	78.5%
М. ТИЛЕУБЕРДИ	78,594.00	100	7,859,400.00	14.7%
Жижиг хувьцаа эзэмшигчид	36,435.00	100	3,643,500.00	6.8%
Нийт дүн	536,177.00	100	53,617,700.00	100%

18. ДАХИН ҮНЭЛГЭЭНИЙ НЭМЭГДЭЛ

2021 онд компани нь хөрөнгийн дахин үнэлгээ хийлгэсэн. Дахин үнэлгээний нэмэгдлийн нийт дүн 4,363,888,720.07 (Дөрвөн тэрбум гурван зуун жаран гурван сая найман зуун наян найман мянга долоон зуун хорин) төгрөг байна.

19. ХУРИМТЛАГДСАН АШИГ, АЛДАГДАЛ

	2023 он	2022 он
Эхний үлдэгдэл	(76,637,865.10)	(110,509,244.09)
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	44,929,178.76	33,871,378.99
Өмчид гарсан өөрчлөлт	-	-
Зарласан ногдол ашиг	-	-
Эцсийн үлдэгдэл	(31,708,686.34)	(76,637,865.10)

Санхүүгийн Тайлангийн Тодруулга 2023.12.31

20. БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО

2022 он болон 2023 оны Дулаан борлуулсны орлого дараах байдалтай байна.

	2023 он	2022 он
Дулаан борлуулсны орлого	6,513,409,736.93	5,069,532,242.02
ЦЭВЭР БОРЛУУЛАЛТЫН ДҮН	6,513,409,736.93	5,069,532,242.02

21. БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ӨРТӨГ

2022 он болон 2023 оны Борлуулсан бүтээгдэхүүний өртөг дараах байдалтай байна.

	2023 он	2022 он
Ажилчдын цалингийн зардал	1,336,372,179.54	987,042,067.03
Аж ахуйн нэгжээс төлсөн НДШ-ийн зардал	184,115,367.31	142,844,298.19
Мэргэжлийн үйлчилгээний зардал	48,904,457.99	46,893,400.00
Ашиглалтын зардал	930,967,304.00	674,150,499.00
Элэгдэл, хорогдлын зардал	901,989,791.76	407,281,512.10
Тээврийн зардал	772,989,467.00	956,490,116.00
Шатахууны зардал	390,493,279.94	257,366,608.50
Ходолмор хамгааллын зардал	94,238,351.00	60,847,570.00
Нүүрсний зардал	796,052,532.00	551,992,770.64
Сэлбэгний зардал	75,416,560.00	45,980,594.09
НИЙТ ДҮН	5,531,539,290.54	4,130,889,435.55

Санхүүгийн Тайлангийн Тодруулга 2023.12.31

22. ЕРӨНХИЙ БА УДИРДЛАГЫН ЗАРДАЛ

2022 он болон 2023 оны Ерөнхий ба удирдлагын зардал дараах байдалтай байна.

	2023 он	2022 он
Албан татвар, төлбөр хураамжийн зардал	91,442,174.17	45,089,307.68
Томиллолтын зардал	11,267,300.00	100,000.00
Бичиг хэргийн зардал	4,990,197.00	5,342,412.60
Шуудан холбооны зардал	24,193,496.26	24,432,872.83
Сургалтын зардал	1,304,900.00	1,826,000.00
Сонин сэтгүүл захиалгын зардал	120,000.00	-
Даатгалын зардал	5,276,375.00	3,740,736.00
Засварын зардал	14,821,500.00	27,578,222.00
Түрээсийн зардал	1,350,000.00	925,000.00
Харуул хамгаалалтын зардал	29,280,000.00	20,024,950.00
Цэвэрлэгээ үйлчилгээний зардал	10,479,840.00	2,271,200.00
Хүлээн авалтын зардал	45,940,120.00	25,754,664.00
ХСОХ зардал	200,000.00	88,500.00
Төлбөр хураамжийн зардал	4,494,002.00	7,374,769.70
Зар сурталчилгааны зардал	435,000.00	21,358,550.00
Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлийн зардал	1,273,860.00	3,672,315.00
Бусад зардал	9,818,838.00	20,391,434.72
НИЙТ ДҮН	256,687,602.43	209,970,934.53

23. САНХҮҮГИЙН ЗАРДАЛ

2022 болон 2023 оны Санхүүгийн зардал дараах байдалтай байна.

	2023 он	2022 он
Зээлийн хүүний зардал	512,084,885.75	490,601,040.52
Бусад санхүүгийн зардал	14,480,255.42	3,044,459.27
НИЙТ ДҮН	526,565,141.17	493,645,499.79

24. БУСАД ЗАРДАЛ

2022 он болон 2023 оны Үйл ажиллагааны бус зардал дараах байдалтай байна.

	2023 он	2022 он
Үйл ажиллагааны бус зардал	179,003,560.19	164,257,955.68
Хандив туслаж	12,413,800.00	15,587,455.00
Найдваргүй авлагын зардал	23,390,786.51	22,193,241.40
Хөрөнгө акталж устгасны зардал	745,300.00	1,583,333.22
НИЙТ ДҮН	215,553,446.70	203,621,985.30